

## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ДОНОЙ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2021.04.23

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр баталсан Орон нутгийн зарим нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх 21/06 удирдамжийн хүрээнд Завхан аймаг дахь Доной нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор Т.Саранчимэг 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймаг дахь Доной нисэх буудлын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Тус нисэх буудлын 2020 оны зардлын төсвийн төлөвлөгөөг нийт 1,347,276.8 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,243,388.4 мянган төгрөг байж нийт зардал 103,880.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоогоор зөрчил илрээгүй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.

Завхан аймаг дахь Доной нисэх буудлын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний салбар нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, үнэлэх журам”-ын дагуу боловсруулсан боловч ИНҮТ-өөс батлаагүй, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр баталсан байна. ИНҮТ-өөс тус Нисэх буудлын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг журмын дагуу хянаж, үнэлээгүй байна.

Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг гаргахдаа Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаар батлагдсан 2017 онд хүчингүй болгосон маягыг ашиглаж байна.

ИНҮТ-ийн дарга 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр “Автомашин, механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын норм тогтоох тухай” А/218 дугаар тушаал баталсан байна. Харин дээрх тушаал тус нисэх буудалд ирээгүй ирсэн бичгийн бүртгэлд байхгүй байна.

2020 онд 10 саяас дээш үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа Завхан аймгийн худалдан авах ажиллагааны газарт хүсэлт хүргүүлэн, тус газраар худалдан авалтыг зохион байгуулуулж ажиллаж байна.

Тус нисэх буудлын ХАБЭА-н ажлыг хариуцсан ажилтнууд ИНЕГ-ын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын 4 дүгээр бүлэгт ...Нэг дэх шатны хяналтыг алба, салбарын доторх зохион байгуулалтын нэгжийн дарга өдөр тутам явуулна... гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй нэг дэх шатны хяналтыг 7 хоногт 1-2 удаа явуулсан байна.

2020 онд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын зөвлөмжийг биелүүлж Дотоод хяналтын баг үзлэг шалгалт, аудит хийхдээ удирдамж батлуулж, тайланг тодорхой бичиж, илэрсэн үл тохирлыг залруулсан байдал, зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хяналт хийж ажиллаж байна.

2020 онд хийгдсэн аудит, хяналт шалгалтаар 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 2, тус нисэх буудалд 4, нийт 6 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА